



**БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2025 оны 05 сарын 29 өдөр

Дугаар А/340

Булган сум

Гадаадад албан томилолтоор ажиллуулах тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.9, 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Сангийн сайдын "Гадаад албан томилолтын зардлын хэмжээ шинэчлэн батлах" тухай 2011 оны 188 дугаар тушаалыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Баян-Агт сумын Засаг дарга Бат-Очирын Бямбажавыг 2025 оны 06 дугаар сарын 7-11-ний өдрүүдэд Япон улсад албан томилолтоор ажиллуулсугай.

2.Албан томилолтын үр дүнг эргэж ирсний дараа ажлын 10 хоногт багтаан илтгэхийг Баян-Агт сумын Засаг дарга (Б.Бямбажав)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Д.ПҮРЭВ-ОЧИР